

ОРОСЫН ТҮҮХ, СОЁЛ ИРГЭНШИЛ

Ж. Баясах*

Оросын соёл иргэншлийг өрнөдийн эрдэмтэд “үнэн алдартны соёл иргэншил” хэмээн нэрлэдэг тал бий. Ийн тодорхойлсны шалтгаан бол Ортодокс Христын шашин шүтдэгээс нь үүдэлтэй. Ортодокс Христын шашин нь эртний Византийн эзэнт улсын үеэс Зүүн өмнөд Европ хийгээд Орост дэлгэрсэн байдаг бөгөөд шашны гүн ухаан, зан үйл нь Христын католик хийгээд протестантын урсгалуудаас өөр байдаг юм.

Оросын соёл иргэншил нь өрнө дорнын зааг дээр оршдог учраас их өвөрмөц бөгөөд ийн төлөвшихөд нь мэдээж шашин хийгээд газар зүйн байрлал үлэмж их нөлөөлсөн хэмээн үнэлбэл зохино.

Оросууд манай монголчуудыг бодвол харьцангуй охор түүхтэй улс юм. Оросын нэртэй түүхчид Н.М.Карамзин (1766-1826), С.М.Соловьев (1820-1879), В.О.Ключевский (1841-1911), С.Ф.Платонов (1860-1933), Б.Д.Греков (1882-1953), Б.А.Рыбаков (1908-?!), Л.Н.Гумилев (1912-1993) нар өөрсдийн түүхээ харилцан адилгүй авч үзэж иржээ.

Археологийн олдвороор бол чулуун зэвсгийн түрүү үед буюу 500-300 мянган жилийн тэртээ өмнө зүгээс хүй нэгдлийн бичин хүмүүс Житомир хийгээд Днестрийн сав нутагт нүүдэллэн ирж аж төрж байсан ул мөр олдсон байдаг. Хожим нь чулуун зэвсгийн дунд үед буюу МЭӨ 100-35 мянган жилийн тэртээ Ижил мөрний дунд болон доод сав газарт бичин хүн амьдарч байсан ул мөр мөн олджээ. МЭӨ 35-10 мянган жилийн үеэс homo sapiens буюу “ухаант хүмүүн”-ий үе эхэлсэн бөгөөд сүргээрээ амьдардаг байснаа больж овгийн байгуулалд шилжсэн хэмээн Оросын түүхчид үздэг болно. Тэр үеийн соёлыг Сунгирийн соёл хэмээдэг бөгөөд Владимир орчмоос олдсон олдвороор ийн нэрлэжээ. Энэхүү соёлын олдворууд нь чулуун зэвсгийн хожуу үеийн хүн ямар шинж төрхтэй байсан, ямар хувцас хунар эдэлж, ямар ахуйн соёлын эд өлгийн зүйл хэрэглэж,

* МУИС, ОУХС-ийн тэргүүлэх профессор, доктор (Sc.D)

ТҮҮХ, СОЁЛ ИРГЭНШИЛ

ямар зан үйлтэй байсныг өгүүлдэг. Хүй нэгдлийн хүмүүс нь ан агнуур, загас агнуур, түүврийн аж ахуйтай байснаа хожим нь газар тариалан, мал аж ахуй эрхлэх болсон байна.

МЭӨ 3000-2000 жилийн үед Орос газар нутагт аж төрж байсан хүмүүс хүрэл зэвсгийн үед шилжин орж аж ахуй эрхлэх хуваарьт нь өөрчлөлт орж, умар зүгийн хүн ард нь ихэвчлэн загас хийгээд ан агнуур, харин тал нутгийн хүмүүс нь мал аж ахуй, газар тариалан эрхлэх болсон ажээ. Хожим нь МЭӨ 1000 жилээс төмрийн үе эхэлсэн бөгөөд төмөр сүх хэрэглэх болсноор мод огтолж тарианы талбайтай болж, газар тариаланг умар зүгт эрхлэх явдал газар авчээ.

Оросын нутагт байсан эртний аймгууд. Хар тэнгисийн хойд эргээр МЭӨ VII-VI зуунд герег олон суурин газрууд бий болжээ. Тэд нутгийн уугуул ард скиф нартай худалдаа хийдэг байсан бөгөөд харилцан нэгнийхээ амьдралд багагүй нөлөө үзүүлсэн гэдэг. Герег нар скифуудээс голдуу талх тариа, загас худалдан авч өөрсдөө бөс даавуу, дарс, элдэв тос хийгээд тансаг хэрэглээний зүйлс худалддаг байжээ. Тэд өөр хоорондоо өргөн харилцаатай байснаас улбаалан холимог суурин газрууд бий болсон нь хожим МЭӨ V-IV зуунд Боспорын аймаг үүсэхэд таатай суурь болов.

Ер нь скиф нарыг Азиас ирсэн хүмүүс хэмээн үздэг билээ. Тэдний гол цөм нь Днепр мөрний доод биеэр нутаглаж байжээ. Днепр мөрний доод баруун эргээр суугчид нь мал аж ахуй эрхэлж байсан бол тэднээс баруун талаар аж төрж байсан скиф нар нь газар тариаланг гол аж ахуйгаа болгон газар хагалдаг байв. Тэд мөн гар урлал эрхэлж байсан бөгөөд нэлээд нарийн хийцтэй багаж зэвсэг хийдэг байсныг археологийн олдвор өгүүлж байна. МЭӨ VI-IV зуунд улс төрийн нэгдэлд орж, Скифын аймгийг байгуулан өнөөгийн Симферополийн ойролцоо төвлөрөн суусан хэмээдэг. МЭӨ III зуунд тэднээс зүүн биеэр суугч сармат нарт шахагдан хөөгдөх болсон. Сармат нар нь Карпатаас Уралын нуруу хүртэлх уудам нутгийг эзэмшиж байжээ. МЭ II-III зуунд сармат нар нь Балтийн тэнгисээс Хар тэнгисийн тал нутагт нүүн ирсэн герман гаралтай Гот овгийнхонд шахагдан дарагджээ. Готуудын удирдагч нь дуу домогт гардаг Германарих гэгч байсан бөгөөд өөрийн харъяанд готуудаасаа гадна фин хийгээд славяны овгуудыг нэгтгэсэн хэмээдэг.

МЭ IV-VI зуунд түүхэнд Их нүүдэл хэмээн тэмдэглэгдсэн том үйл явдал болсон бөгөөд Азиас Европ руу үй олон хүн ард Уралын нуруу, Каспийн тэнгисээр дамжин Дорнод Европт нүүдэллэн ирсэн. Эл хүн ард нь Хүннү улсын харъяанд байгсад байв. Тэд замдаа готуудыг бут цохиход, толгойлогч Германарих цөхрөнгөө барж амиа хорлосон хэмээн түүхэнд бичигдэн үлдсэн байдаг. Монголчуудын өвөг улс болох Хүннү нарын

тасархайчуул Аттила хэмээгч 440 онд хаан болсноос хойш хамгийн их сүр хүчийг олж Дунай мөрний сав газар нутаглаж Ромын эзэнт улсын баруун зүүн бие нутгийг их түйвээж Адриатын тэнгис хүрч байсан. Аттила хаан 453 онд өөд болоход Хүн нар нь бутарсан байна. Аттила хааныг өнгөрөхөд гурван давхар авсанд хийж оршуулжээ. Эхний авс нь алтаар хийсэн, хоёр дахь нь мөнгөөр хийсэн, гурав дахь нь төмөр авс байжээ. Энэ нь ард олондоо алт, мөнгө авчирч жаргуулсан, харин харь түмэнд төмөр мэт хатуу дориун байсан гэдгийг илтгэж байсан хэмээдэг. Европд очсон хүннү нарыг өрнөдийн түүхчид Хүн нар гэж бичдэг. Тэдний хойч үе нь өнөөгийн Мажар улс (англиар Хүнгари) буюу Унгар улс юм.

ҮІ зуунд Хүн нарын оронд аварууд хүч түрэн гарч ирсэн бөгөөд тэд Дунай мөрний саваар нутаглагч хүн ардыг хийгээд славян нарыг ноёрхож байв. ҮІІ зуунд өөр нүүдэлчид болох хазар нар нь хүчирхэгжиж Кавказын нуруунаас Ижил мөрөн хийгээд Днепр мөрний дунд хүртэлх өргөн уудам газар нутагт өөрийн Хазарын хаант улсыг байгуулсан бөгөөд 200 жил ноёрхон суусан байна.

Дээр өгүүлсэн нүүдэлчид нь өнөөгийн Орос улсын өмнө хийгээд төв биеэр ноёрхон сууж байсан бөгөөд энэ нь оросууд хожуу үүссэн залуу үндэстэн болохыг давхар нотлох буюу.

Славянуудын уг гарал. Славянуудын угсаа гарлын талаар эрдэмтэд харилцан адилгүй байр суурьтай байдаг. Гэхдээ бүх эрдэмтэд ХІІ зууны эхээр Нестор ламын бичсэн хэмээдэг “Повесть временных лет” буюу “Он цагийн тууж” сурвалж бичгийг үндэс болгодог байна. Түүний бичсэнээр бол славян нар Ромын Норик мужид оршин сууж байсан бөгөөд тэрхүү газар нь Дунай болон Драва мөрний эх газарт байжээ. Тэднийг ромчуул шахаж эхэлмэгц Висла, Днепр мөрний сав газар нүүдэллэн иржээ.

Оросын түүхч С.М.Соловьев хийгээд В.О.Ключевский нар славянуудын өлгий нутаг бол Дунай мөрөн хэмээн үздэг. Харин В.О.Ключевский славян нар Дунайгаас Днепр лүү нүүдэллэн ирэхээс өмнө 500 жил Карпатын нурууны хормой газраар нутаглаж байгаад ҮІІІ зуунаас дорнод славян нар аажимдаа Оросын нам дор газар шилжин суурьшсан хэмээн үздэг.

Зөвлөлтийн эрдэмтдийн нэг хэсэг нь славян нар Дунай мөрнөөс гаралтай гэдгийг хүлээн зөвшөөрдөг байсан бол ихэнх нь славянуудын өлгий нутаг бол умарт зүгт байсан хэмээн үзэж байв. Гэхдээ чухам аль газар өлгий нутаг нь байв гэдэг дээр маргаантай байсан. Нэг хэсэг нь славянуудын өлгий нутаг бол Днепр мөрний хавьцаах нутаг болох

Припять гол дагуу нутаг мөн гэдэг бол нөгөө хэсэг нь Висла хийгээд Одер мөрний бэлчирт нутаглаж байсан хэмээн харилцан адилгүй байр суурийг баримталдаг болно.

Харин археологич, түүхч академич Б.А.Рыбаков дээрх хоёр байр суурийг нэгтгэн археологийн тухайн үеийн ололт дээр тулгуурлан дээр өгүүлсэн нутаг орон бол славянуудын өлгий нутаг байх талтай хэмээн үзэж байв. Түүний үзэж байснаар славянуудын өвөг дээдэс нар Төв хийгээд Дорнод Европын өргөн уудам нутагт аж төрж байсан агаад газар нутаг нь умартаас өмнө рүү ойролцоогоор 400 км, харин баруунаас зүүн зүг рүү бараг 1,5 мянган км байсан байна. Баруун зүгийн нутгийн өмнө бие нь Европын Судет хийгээд Татар болоод Карпатын нуруугаар зааглагдаж байсан бол умарт нутаг нь Балтийн тэнгис хүрч байв. Зүүн талын нутаг нь хойт биеэрээ Припять гол хүрч, харин өмнө талдаа Днестр мөрний дээд урсгал хийгээд Днепрт цутгадаг Роси голын сав газар хүрч байсан гэдэг.

Б.А.Рыбаков славян нар нь эртний Энэтхэг-Европын нэгдэлд хамаарагдана гэж үзэж байсан бөгөөд тэрхүү нэгдэлд Герман, Иран, Кельт, Энэтхэг, Гэрэг зэрэг ард түмнүүд орж байсан. Энэтхэг-Европын нэгдэл нь эхэн үедээ буюу 4-5 мянган жилийн тэртээ Балканы хойг болон Бага Азийн зүүн хойт нутагт суурьшиж байв. Харин МЭӨ III-II мянган жилийн заагт Европ тивийн хойт нутаг Рейнээс Днепр мөрний хооронд оршин суугчид мал аж ахуй эрхэлж байсан тул МЭӨ II мянган жилээс бэлчээр хайн Дорнод Европын нутагт өргөн тархан суух болжээ.

Чухамхүү тэдний дотор Славянуудын өвөг дээдэс орж явжээ. Тэдний нутаглаж байсан газар нь баруунтаа Одер мөрөн, зүүн зүгт Днепр мөрний дээд урсгал, өмнө зүгт Карпатын нурууны хойт уулс, умар зүгт Припять гол байв.

Герегийн түүхч Геродотын номд МЭӨ V зуунаас славянуудын талаар анх бичиж тэмдэглэл үлдээжээ. Мөн хожуу үеийн герегийн түүхч Полибий, Тит Ливий, Страбон, Тацит нарын зохиолд Славянуудын талаар Венедууд хэмээсэн нэрээр цухас зүйлс бичигдэн үлдээсэн байдаг. Тэднийг Висла мөрний сав газарт Скиф хийгээд Сармат нарын дунд аж төрдөг хэмээн өгүүлсэн байдаг. Слав нарын тухай нэлээд дэлгэрэнгүй бичсэн хүмүүс бол Византийн түүхч Кессарийгийн Прокопий (500-565) хийгээд Готын түүхч Иордан (VI зуун) нар юм.

МЭ VI зуунд удаах дэлхийн их нүүдэл болоход Славян нар гадна үлдээгүй байна. Энэ үед их улсууд задарч, оронд нь шинэ хүчирхэг улсууд үүсч хөгжих болсон юм. Тухайлбал, IV зуунд Ромын их эзэнт улс задарч оронд нь Баруун Ромын улс

байгуулагдсан байна. Харин Балкан хийгээд Бага Азийн нутаг дээр Зүүн Ромын улс байгуулагдаж, Константинополь хотыг нийслэлээ болгосон агаад хожим Византийн эзэнт улс хэмээн нэр нь өөрчлөгдсөн бөгөөд 1453 он хүртэл оршин тогтносон юм. Византийн эзэнт улс нь герегийн соёлыг өвлөж авсан бөгөөд Европын хүчирхэг хөгжил сайтай улс байв. Энэ улс хөрш зэргэлдээ хийгээд тэдэнтэй худалдаа хийдэг Славян нарт асар их нөлөө үзүүлсэн билээ.

Ү-ҮII зуунд Өрнөд Европт Германы овог аймгууд тархан суух болсон бөгөөд Франк, Вестгот, Лангобардын зэрэг ханлигууд бий болсон байна.

ҮI зуунд славянууд дэлхийг хамарсан их нүүдэлд хамрагдаж гурван чиглэлээр нүүдэллэх болсон бөгөөд ҮI-ҮIII зуунд нэг хэсэг нь өмнө зүг Балканы хойг, нөгөө хэсэг нь өрнө зүг Одер хийгээд Эльба мөрний бэлчир, дараах нь дорно хийгээд умар зүг Дорнод Европын нам дор газар луу нүүдэллэн очсон байна. Мөн үед Славян нар нь өмнөт, өрнө хийгээд дорно зүгийнхэн болж хуваагдах үйл явц өрнөжээ. Өмнөд Слав нарт өнөөгийн Болгар, Серб, Хорват нар ордог бол өрнөд Слав нарт Польш, Чех, Словак нар, дорнод хэсэгт нь Орос, Украин хийгээд Беларусь тус тус харьяалагдах болов.

Эртний Орос улс байгуулагдсан нь. Европын дундат зууны томоохон улсын нэг бол IX-XII зуунд оршин тогтнож байсан Киевын Орос улс юм. Орос улс төлөвшин тогтнох үйл явц өрнөд хийгээд дорно зүгийн улсуудаас өөр өвөрмөц шинжийг агуулж байсан юм. Энэ улс нь газар зүй хийгээд геополитикийн өвөрмөц байдалтай байсан нь үүнд шууд нөлөөлсөн байна. Тэр үед Европ хийгээд Ази хоёр тивийн зааг тодорхойгүй байсан бөгөөд хоёр тивийн нөлөөлөл нь тус улс бий болоход ул мөрөө үлдээсэн бөгөөд энэ нь тэр даруйдаа бус харин дараа дараагийн зуунд нөлөөгөө хүчтэй үлдээсэн гэвэл зохистой болно. Ер нь эрт өдгөөгийн Орос улс ямагт хоёр тивийн соёлын уулзвар байсны зэрэгцээ энэ орон зайд буй болсон улс нь хоёр тивийг холбосон Евразийн төрийн тогтолцоог хадгалж ирсэн болно.

Дээр өгүүлсэн Нестор хэмээгч санваартан түүхчийн бичсэнээр МЭ ҮI зуунд Днепр мөрний доод бие нутгаар хэд хэдэн Славян овгууд нэгдэн аймгийн холбоо байгуулсан бөгөөд тэдний дунд нэгэн овог байсан нь “рос” буюу “рус” хэмээсэн нэртэй байжээ. Энэ овог нь чухамхүү өнөөгийн Оросууд бололтой юм. Тэд VIII-IX зуунд өнөөгийн Киев хотын тус газар хүрээлэн суух болсон бөгөөд газар нутгийн хувьд үлэмж их өргөн уудам нутгийг эзэмшин сууж байжээ. Тэдний эзэн нь Рюрих (?-879) гэгч байсан гэдэг. Тэрээр Новгород хотыг захиран сууж байсан бол ах дүү нар нь Белоозер болоод Изборск зэрэг

газрыг захиран суудаг байсан байна. Рюрих эзэн өөд болоход Игорь угсаа залгамжилсан бөгөөд 882 онд Олег вангийн туслалцаатайгаар Новгород хийгээд Киевийн газруудыг нэгтгэн Киевийн Орос хэмээх Киевт төвтэй Оросын эртний улсыг байгуулжээ. Тухайн улсын дотоод байдал нь тогтворгүй байсан бөгөөд эзэмшил нутгаасаа татвар нэмэгдүүлэн авах гэж яваад Игорь ван 945 онд алуулжээ. Түүний орыг Святослав (942-972) залгамжилсан бөгөөд тэр төр барихын сацуу цэргийн явдалд гарамгай байсан гэдэг. Тэрээр Ижил мөрний Булгарууд болон Мордовын овгууд хийгээд Хазарын ханлигийг байлдан дагуулснаас гадна Умард Кавказ болон Азовын тэнгис хүртэл аян дайн явуулж Печенег нарын дайралтанд хариу цохилт өгч байв. Гэвч Византи руу аян хийж яваад буцах замдаа Печенег нарт бут цохиулж амиа алдсан байна. Түүний орыг залгамжилсан хүү Владимир (960-1015) ван дорнод славян нарыг Киевийн Оросын харъяанд оруулсны дээр нүүдэлчдийн довтолгооныг зогсоохын тулд хил дагуу цайз бэхэлгээ босгосон байна. Түүнийг ард түмэн “Красное Солнышко” хэмээдэг байжээ. Оросууд төр барьж байгсаддаа элдэв хоч өгдөг уламжлал нь бараг энэ үеэс гарсан болов уу хэмээн үүнийг тэрлэгч би боддог юм.

Киевийн Орос нь аажимдаа төр улсын шинжийг олсон бөгөөд төрийг ван удирдаж, доор нь язгууртан бояр нар байж, ванд зүтгэж, цэргийн алба хашдаг байсан юм. Ван нутаг эзэмшлээ бояр нарын думаар дамжуулж захиран суудаг байв. Бояр нарын дума нь дайн энхийн асуудал, ванг сонгох, гадаад улстай гэрээ байгуулах, хууль дүрэм гаргах, зарга шүүх, сан хөмөргийн явдлыг хэлэлцдэг байжээ. Тухайн нийгмийн гол цөм нь хүн ардын ажил хөдөлмөр, зан үйл хийгээд соёлын үйл ажиллагааг удирддаг хүй болж байв. Тус улс байнга тал нутгийн халдлагад өртдөг байсан тул Монголын өвөг улсуудаас улбаатай аравтын тогтолцоог авч хэрэглэсэн бөгөөд өрхийн цэргийг аравт, зуут, мянгатын зохион байгуулалтанд оруулж, түүнийг нь ардын вече хэмээгч хурал удирддаг байсан. Дараах зуунд ардын хурал нь голлох үүргээ алдах болсон ч Новгород, Киев, Псков зэрэг хотуудад хэдэн зуун жил нөлөөтэй байсан болно.

Оросууд газар тариалан, мал аж ахуй, ан агнуур, загас агнуур хийгээд гар урлал эрхэлдэг байв. Киевийн Орос улсад хувийн газар эзэмшлүүд буй болсон бөгөөд түүнийг “вотчина” хэмээн нэрлэж байв. Вотчина газрыг худалдах буюу худалдан авахыг хориглож байсан авч угсаа залгамжлан өвлүүлэхийг зөвшөөрдөг байв. Вотчина эзэмшлийг ван, боярууд, сүм дуганых гэж дотор нь ялгадаг байв. Газар боловсруулдаг тариачид нь

яваандаа бояруудын хараат болж байсан бөгөөд газар эдэлсний татварыг газрын эзэн хийгээд улсад төлдөг болсон байна.

Тэр үед феодалын харилцааг бататгасан “Русская правда” хэмээх хууль цаазны бичиг гарсан бөгөөд түүнийг нь ХҮ зуун хүртэл хэрэглэж байв. Энэхүү хууль цаазны бичигт дурдсанаар оросууд арилжаа наймаанд мал хийгээд үслэг эдээр барааг арилжаалахаас гадна “гривна кун” хэмээх зоос хэрэглэж байжээ. Энэхүү зоос ХІҮ зуунд “рубль” хэмээх мөнгөн тэмдэгт гартал хэрэглээнд байсан байна.

Тэр үеийн Оросын улс төр хийгээд нийгэм эдийн засгийн амьдралаас гадна оюуны амьдралд том өөрчлөлт гарсан юм.

Тухайн үед Оросын хөрш улсууд болох Ижил мөрний булгарууд лалын шашинтай, харин хазарууд бүр Иудейн шашинтай байсан тул Орос улс өөрийн шашинтай болж ард олноо оюун санааны нэгдсэн жолоонд оруулах замаар улс орноо төвхнүүлэх шаардлага гарч ирсэн юм. Ингээд Анхдугаар Владимир ван Киев хотноо Зөвлөлийн тусгай чуулга хуралдуулж шашин сонгуулахаар тогтоод, эл зорилгоор элч нарыг харь улс руу томилон явуулах болсон бөгөөд төдөлгүй христосын ортодокс урсгалыг шашинаа болгон авчээ. Христосын шашны эртний буюу ортодокс урсгалыг Оросууд Византийн гүрнээс авсан бөгөөд аажимдаа өөрийн гэсэн орос маягийн төрхийг олж “православие” хэмээн нэрлэгдэх болсон бөгөөд энэ нь угтаа “үнэн итгэл үнэмшил” хэмээсэн утгатай авч, манайд “үнэн алдартан” хэмээн үгчлэн орчуулсан ташаа нэрийдлээр хэрэглэж дасал болжээ. Энэ шашны урсгал нь хүний дотоод сэтгэлийг өөрчлөх тал дээр илүү анхаардаг учраас нийгмийг хөгжил дэвшилд хүргэх болон бодит амьдралыг өөрчлөн сайжруулах тал дээр бага анхаардаг хэмээн Оросууд өөрсдөө буруушаан үздэг байсан нь саяхан. Ийм ч учраас энэ нь Оросын хэтийн хөгжилд сөрөг нөлөө үзүүлсэн гэдэг.

Энэхүү христосын православ урсгал нь номлол, сүм дуган хийгээд зан үйл зэргээрээ христосын шашны католик хийгээд протестант урсгалуудаас тэс өөр байдаг. Иймээс гол сургааль нь Евангелий хэмээх сударт байдаг болно. Загалмай нь гэхэд мөн өөр байдаг. Ер нь л бусад христосын урсгалуудаас өөр юм. 1453 оноос хойш Москва хот ортодокс христосын шашны төв болж хувирсан. Үүнээс өмнө Костантинополь хот ортодокс Христос шашны төв байсан.

Анхдугаар Владимир ван өөрийн 12 хөвгүүддээ газар нутгаа хуваан өгснөөс хойш, ялангуяа түүнийг өөд болсны дараагаар Орос улс тархай бутархай байдалтай болж өөр хоорондын дайн газар авч, улмаар 1019 онд засгийн эрхийн төлөө ширүүн тэмцэл өрнөсөн

нь Ярослав (978-1054) вангийн ялалтаар дуусч, тэрээр хаан ширээнд сууж, ард олон дунд Ярослав Мудрый буюу мэргэн Ярослав хэмээн алдаршсан байна. Түүнийг хаан байхад Киевийн Орос улс хөгжлийнхөө дээд оргилд хүрсэн гэж үздэг бөгөөд тэрбээр Печенег нарын довтолгооныг дарж чадсан агаад улс нь нэг хэсэгтээ амар амгалан болж 13 бөмбөгөр орой бүхий Софигийн дуган хийгээд Печерийн дуган зэргийг босгосны дээр бүх нийтийг бичиг үсэгт сургах болж, олон арван ном зохиолыг герег хэлнээс орос руу орчуулж гаргажээ. Мөн Софигийн дуганд номын сан байгуулсан байна.

XII зуунд Киев хот Оросын улс төрийн амьдралд голлох үүргээ алдаж, улмаар дахин Ази гаралтай тал нутгийн нүүдэлчид болох Печенег хийгээд Половчуудын хөлд үрэгдэж удаа дараа тэдний дайралтанд өртөх болсон байна.

Мөн энэ үед Суздаль, Ростов, Владимир, Москва зэрэг хотууд өргөжин том болж гол гол суурин газрууд болжээ. Суздалийн ван Андрей Боголюбский (1157-1174) Киев хотыг тонон дээрэмдэж байв. Улмаар Новгород хот нь Киевээс илүү хөгжин худалдааны гол төв нь болсон байна. Александр Невский (1246-1263) Оросын тусгаар тогтнолыг хамгаалж Герман хийгээд Шведүүдийн эсрэг ширүүн тэмцэл өрнүүлж Киевийн Оросыг нэгэн хэсэгтээ хамгаалж чадсан хэдий ч Киев нь Владимир хийгээд Суздаль хотуудын өмнө хүч мөхөсдөх болжээ (1, р.290).

XIII зууны эхээр Орос орон монголчуудын хөлд үрэгдэх болж 1223 онд Калка голын дэргэд Орос Монголын хооронд тулалдаан болж, улмаар 1237 онд Бат хааны цэрэг Оросын Рязань, Суздаль, Москва зэрэг хотыг эзэлж, 1238 он болоход өөр 14 хот монголчуудад эзлэгдсэн байв. 1242-1492 онд Орос орон Бат хааны байгуулсан Алтан Ордны улсын бүрэлдэхүүнд орсон. Алтан Ордны улс нь Уралын нуруунаас Карпатын нуруу хүртэлх өргөн уудам нутгийг эзэмшиж байсан юм. Алтан Ордны нийслэл нь 1243 оноос Ижил мөрний эрэг дэх Сарай хот болов. Бат хааны дараагаар Бэркэ 1257-1267 онд хаан ширээнд суусан бөгөөд түүнийг лалын шашинд орсон нэгэн байсан хэмээн Г.Вернадский бичсэн байдаг. Бэркэ хааны орд сууснаас авахуулан дараах 50 жил Алтан Ордны улс лалын шашинтай байсан хэмээн үздэг байна. Чухамхүү энэ үеэс эхлэн Алтан Ордны улс эх нутгаасаа тасархай байх болжээ. 1359 онд Бэрдибилиг хаан өөд болсны дараагаар тус улс дотоодын хор хөнөөлтэй тэмцэлд идэгдэж байсан байна. Улмаар 1381-1395 онд Тохтамиш хаан сууж байхад Алтан Ордын улс дахин сэргэж Зүүн Кипчакийн Цагаан Орд улсыг өөртөө нэгтгэсэн. Гэвч 1395 онд доголлон Төмөрт эл нутгийг алджээ. 1399-1419 онд хаан байсан Эдэгэйгээс хойш эл улсын хил хязгаараар нь бие даасан

Астрахань, Казань хийгээд Крымийн хаант улсууд байгуулагдсанаар хүч нь бүр доройтсон байна (1, pp.149-150).

Алтан Ордын улсын үед монголчууд өөрийн ноёрхогч байдлаа нутгийн суугуул оросууд болон бусад угсаатнуудад ойлгуулж мэдрүүлэхийн тулд үс засал тавих хийгээд хувцас хунар өмсөх дэг жаяг, алба гувчуур барих, өртөө зам эрхлэх, элч илгээх, төрийн ёс үйлдэх зэрэгт өөрийн уугуул ёсоо ягштал мөрдөхийг тулгасан байна. Тухайлбал, суугуул иргэд бүгд нь монгол ёсоор үсээ засахдаа “хөхөл” тавих болж энэ нь орос хэлнээ “хохол” гэсэн үгээр бууж тусгайлсан ойлголт бий болгож өнөөг хүрсэн байна (2,93-94-р тал). Эрчүүд нь хөхөл тавьж, эмс нь шивэргэл, бага охид үсээ хоёр хуваан тал тус бүртээ олон салаа сүлждэг монгол ёс Их Монгол улсын үндсэн хийгээд харъяаны бүх нутагт түгээмэл хэрэглэгдэж байсан юм. Монголчууд мөн бүх эзэнт гүрний нутгийг өртөө замын сүлжээнд оруулсан нь Орос оронг ч мөн алгасаагүй болно. Зам гэдэг монгол үг “ям”, “яма” гэдгээрээ дэлгэрсэн бөгөөд орос хэлнээ үүнээс үүдэн “ямчин”, “ямщик”, “ямской”, “ямской приказ”, “ямская повинность” гэсэн үг хэллэг, тусгайлсан ойлголтууд буй болсон (2,97-98-р тал).

Оросын түшмэг ван нар монгол төрийн ёсонд захирагдан Мөнх хийгээд Гүюүг нар хааны орд суух “inauguration” ёслолд ирдэг байв. Алтан Ордоны үеэс орос хэлэнд хохол (хөхөл), джида (жад), терем (тээрэм), яма (зам), ямщик өртөөч), доха (дах), аврал, хуралдай, малгай гэсэн олон монгол үгс орж үгийн санг нь баяжуулсан байдаг. Мөн монголчуудын харъяанд байсан газарт монгол газар усны нэр ихээр үлдээж хоцорчээ. Тухайлбал, Астрахань буюу Астрын дархан, Калуга буюу Хаалга, Саратов буюу Шар дов, Тюмень буюу Түмэн, Есентуки буюу Есөн туг г.м. Түүнчлэн монголчууд нутгийн орос хийгээд бусад туургатан нартай 250 жилийн дотор их цус холилдсон бөгөөд тэртээ тэргүй оросууд өмнө нь тал газрын монголжуу төрхтэй Авар, Сармат, Хазар, Печенег, Половчуудтай холилдсон цус нь улам бүр өөрчлөгдөж өнөө цагийн оросууд болон украин, белорус нар цагаан арьстан гэхээсээ илүү монголжуу төрхийг олж өөр генийн фондтой болсон. Орос язгууртан дунд Ордынский хэмээх овог үүсэхэд хүргэсэн болно.

Дээр өгүүлснээс гадна өөр нэг чухал үр дагавар Оросын түүхнээ гүнзгий ул мөрөө үлдээсэн бөгөөд тэр нь чухамхүү Монголын дарлалд байснаар оросууд үндэстэн болж төлөвших үйл явцыг олсноос гадна хожим нь нэгдэн нягтарч Оросын их гүрэн байгуулахад онцгой чухал үүрэг гүйцэтгэж агуу их түлхэц өгсөн байна. Үүнийг ЗХУ оршин тогтнож байхад үлэмж хэлмэгдэж байсан Оросын агуу их түүхч Л.Н.Гумилёв

зоригтой гаргаж тавьсан бөгөөд түүний энэхүү номлолыг Их Оросын шовинист үзэлд автсан түүхчид хүлээн зөвшөөрөхгүй жадлан угтсан ч “үнэн юм даравч далдайдаг” гэдэг үлгэрээр өдгөө нэгэнтээ хүлээн зөвшөөрөгджээ.

Орос улс нэгдмэл нэг улс болсон хураангуй. ХҮI зуунд III Василий вангийн үед (1505-1533) Москва орчмын газарт Оросын ванлигууд нэгдэх үйл явц дууссан хэмээн үздэг. 1510 онд Псков хот Орос улсын харъяанд орж, 1514 онд урьд Литвын феодалуудын харъяанд ороод байсан Смоленск хотыг эгүүлэн авсан агаад, 1521 онд Рязаний ванлигийг нэгтгэсэн болно. Ийнхүү Оросын бүх ванлигууд нэг захиргаанд орсон бөгөөд Оросуудын зэрэгцээ Удмуртууд, Мордва, Карелчууд, Коми нар үүнд багтжээ.

III Иван хийгээд III Василий нар Москваг захирч байх үеэс Оросын батлан хамгаалах хүч чадал нь нэмэгдэж харийн, тухайлбал, Германы хаан, Унгарын ван, Данийн ван, Венецийн жоа, Туркийн султаны элч нарыг хүлээн авдаг болсноор гадаад нэр хүнд нь дээшлэх болжээ.

III Василий өөд болсны дараагаар IV Иван хаан ширээнд 3 настай суусан бөгөөд (1530-1584) түүний багад эх нь болох их хатан Елена Галинская улсыг төвлөрүүлэн захирах, шинэтгэлийн ажил явуулж, төрийн хүмүүс газраа худалдаалах явдлыг хорих хийгээд сүм дуганы эзэмшил нэмэгдэхэд хориг тавих арга хэмжээ авч байсан байна. 1535 онд их хатан мөнгөний шинэчлэл хийж мөнгөн рублийг гүйлгээнд оруулж хуурамч мөнгө хэрэглэх явдлыг зогсоож чадсан нь их буянтай ажил болсон гэдэг. Рублийг Москва болон Новгородод тусгайлан цутгах болсон байна. Их хатан 1538 онд өөд болоход Иван албан ёсоор төр барьж эхэлсэн бөгөөд Бельский, Шуйский, Глинский нарын овгийнхонтой засгийн эрхийн ширүүн тэмцэл явуулж, ялсан тэрээр ард түмэн дунд Догшин Иван хэмээн нэрлэгдэх болсон. Тэр 1543 онд бүр 13 настай байхдаа анх цаазаар авах ялыг гүйцэтгүүлсэн байна. 1547 онд Оросын хаан цол хүртэж, анх удаа Успенский дуганд Оросын хаадаас ураг барилдсан болно. Мөн ондоо тэр Избранная Рада хэмээх нэрээр шинэ засгийн газар байгуулж бояр нарыг засгийн газрын хэрэгт оролцуулах явдлыг цөөлөх болсон байна.

1549 оноос засгийн газрын яамд “приказ”-ыг байгуулсан байна. Гадаад асуудал эрхэлсэн яамаа “Посольский приказ”, зэвсгийн яамыг “Пушкарский приказ”, феодалын эзэмшлийг хамгаалах яамаа “Разбойный приказ”, улсын санхүүг барьдаг яамаа “Большой приказ”, шуудан тээврийг хариуцсан яамаа “Ямской приказ”, ноёдын эзэмшил хариуцсан

яамаа “Поместный приказ”, мөн зарим газрыг тусгайлан хариуцсан яамдыг “Приказ Сибирского двора” хийгээд “Приказ Казаньского дворца” зэргээр нэрлэсэн байна.

Догшин Иван 1556 онд “Уложение о службе” хэмээсэн зарлиг гаргаснаар бояр хийгээд дворян нарын хүүхдүүд 15 настайгаасаа төрийн албыг бүх насаараа угсаа залгамжлан хаах болгосон нь зэвсэгт хүчнээ бэхжүүлсэн арга хэмжээ болсон агаад мөн эгэл түмний дундаас дайчилгаагаар нум сум харваач нарыг бэлтгэдэг байв. Түүнчилэн Доны казак нараар хил хязгаараа хамгаалуулах болсон байна.

Догшин Иван 1552 онд Казаний хаант улсыг, улмаар 1556 онд Астраханий хаант улсыг буулгаж аваад, мөн ондоо Сибирийн хаан Эдгейг эрхшээлд оруулсан авч түүний орыг залгамжлагч Кучум Москваг үл тоох болсон тул казахын атаман Ермакийн цэргийг Сибирьт илгээн, нийслэл Кашлык хотыг эзэлсэн байна. Ермак 1598 онд Кучумыг эцэслэн цохиж, Баруун Сибирь Оросын эзэнт улсын мэдэлд оржээ.

Ингээд ХҮI зууны эцэс болоход Оросын газар нутаг 50 жилийн дотор 2 дахин нэмэгдэж хүн ам нь 7 сая орчим болов. Тэр үед газар тариаланд анжис хэрэглэх болсноор газар тариалан нь эрчимтэй аж ахуй болж ирсний хамт гар урлал худалдаа хөгжиж Орос орон 220 хот суурингуудтай болжээ.

Догшин Иваны дараа Орос орны дотоод байдал самуурч олон хааны нүүр үзсэн бөгөөд арай нэрд гарсан нь Борис Годунов (1598-1605), Василий Шуйский (1606-1610), Семибоярщина (1610-1613) буюу олон ванлиг болсон үеүд юм.

Орос орны түүхийг хөгжлийн шинэ шатанд гаргасан удирдагч нь Анхдугаар Петр (1672-1725) хаан билээ. Түүний хаанчлалын үед Орос оронд хаант засаг бүрэн гүйцэд төлөвшиж ирсэн бөгөөд хэмжээгүй эрхт хаанчлал тогтсон байна. Тэр Бояр нарын думыг өөрчлөн, өөртөө хамгийн үнэнч 9 хүнээс бүрдсэн Сенатыг байгуулсан ба Приказуудыг халж оронд нь 12 коллегийг байгуулжээ. 1721 онд шашны хэрэг эрхэлдэг Духовная коллегия гэгч яам байгуулсан болно. 1708 онд амбан захирагчаар удирдуулсан 8 губернийг байгуулсан агаад амбан захирагч нь цэрэг захирах эрхтэй байв. Губернийн газар нутаг өргөн уудам байсан тул дотор нь 50 муж болгож дахин хуваарилалт хийжээ. Петр хаан арми хийгээд флотыг шинэчлэхэд үлэмж анхаарч 1705 оноос 20 тариачны өрхөөс нэг хүнийг бүх насаар нь цэрэгт татдаг журам гаргав. Арми энэ үед дүрэмт хувцас хэрэглэдэг болж зэвсгийн нэгдсэн нэг хэрэглээнд шилжиж, армийн нэгдсэн сахилга бат мөрдүүлэх болж, нарийн хатуу дүрэм журам зохион хэрэглэх болов. Түүнчлэн офицерийн сургууль байгуулсан байна. Армид энэ үеэс хүнд артиллерийн зэвсэг хэрэглэх болсны дээр усан

онгоц барих болжээ. Ингээд 1725 онд болоход Балтийн флот 30-аад шугамын онгоц, 16 дарвуулт фрегат онгоц, бараг 400 тээврийн онгоцтой болсноор Оросын арми болон флот Европт толгой зохих хэмжээнд хүрчээ. Петр өрнөдийн жишгээр мануфактур байгуулахад үлэмж анхаарч байсны хэрээр 1725 онд тус улсад 205 үйлдвэрийн газартай болов. Ширэм төмөр үйлдвэрлэлээрээ Англи, Швед улсын дараагаар орох болжээ. Ер нь Анхдугаар Петрийн үед Орост шинээр усан онгоц үйлдвэрлэл, торгоны үйлдвэрлэл, шил болон шаазан үйлдвэрлэл, цаас үйлдэрлэл зэрэг аж үйлдвэрийн салбарууд байгуулагдсан. Петр хаан эзэнт гүрний нийслэл Петроградыг байгуулсан бөгөөд энэхүү хот том худалдааны төв хийгээд боомт болсон төдийгүй хожим нь Амстердам хотыг өвчсөн Европын сайхан хотын нэг болсон билээ. Түүнчлэн Петр хаан 1679 онд хүн амын ихэнх хэсгийг хамжлагат ёсонд оруулсан билээ. Тэр үеийн хүн амын тооллогоор Орос орон нийт 15,5 сая хүнтэй байснаас 5,4 сая эрчүүд тоологдсон бөгөөд тэд татвар төлөгч болж байв. Мөн 1724 онд тариачид газрын эзний бичгэн зөвшөөрөлгүйгээр хөлсний ажил хийхийг хориглосон нь угтаа паспорт дэгд орсон хэрэг байв.

Петр хааны дараа Елизавета Петровна (1709-1761), ялангуяа II Екатерина (1729-1796) нар хаант төр захирч байх үед Орос улс цаашдын хөгжлийг олж 2000 үйлдвэрийн газруудтай болж зарим нь бүр 1200 ажилчинтай байв. Энэ үед Уралд уул уурхай металлургийн том цогцолбор босч ирсэн бөгөөд ширэм хайлуултаараа дэлхийд тэргүүлэх болжээ. Екатерина хатан хаан өрнөдийн соёлыг Орост түгээхэд үлэмж их зүтгэсэн нэгэн билээ.

Энэ хоёр хатан хааны дараагаар Анхдугаар Александр (1777-1825) хааны үед Оросууд гадаадад чөлөөтэй зорчдог болсон, Одесса хот анхны татваргүй худалдаа хийдэг хот болж, 1801 онд газар худалдах албан зөвшөөрөл олгосон, 1812 оны Эх орны дайн болж францчуудыг ялсан хийгээд хамжлагат ёсыг халахыг тариачид шаардаж самуун гаргасан, мөн либерал үзлийг дэлгэрүүлэхийг шаардсан 1825 оны декабристуудын хөдөлгөөн гарсан зэрэг үйл явдлуудаар дүүрэн он жилүүд байв.

Дараа нь Анхдугаар Николай (1825-1855) хаан ширээнд сууж байхад Оросууд 1830-аад онд Чеченийг эзэлсэн, мөн 1864 онд Кавказыг эзэлсэн болно. Харин түүний дараа гарсан II Александр (1818-1881) хааны үед 1861 онд хамжлагат ёсыг халж, эрчимтэй аж үйлдвэржиж эхэлсэн юм. Ийн байдалтайгаар Орос орон XX зуунтай золгосон бөгөөд Оросын хаант төр унагасан Большевик хувьсгал гарч, ЗХУ нэртэй үзэл суртлын эзэнт

гүрэн 1917 оноос оршин тогтнож улмаар 1991 онд задарч, ТУХН гэгч бий болж өнөө үетэй золгосон билээ.

Ерөнхийлөн онцлох зүйл гэвэл, Орос улс ямагт Евразийн улс байсан, зүс царай хийгээд сэтгэлгээний хувьд өрнөдөөс ялгаатай, түүх нь хэдий богино ч сонин, монголчуудын дарлалд байснаар их улс болж чадсан, дэлхийн уран зохиол, урлаг хийгээд шинжлэх ухаанд олон арван суут хүмүүс төрүүлж өгсөн соёлт улсын нэг мөн.

Ном зүй:

1. *The Middle Ages: A Concise Encyclopaedia, Thames and Hudson, London., 1989*
2. *Хэрээд Жамсрангийн Баясах. Их Монгол Улсын түүхэнд холбогдох хятад хоёр сурвалж бичиг, УБ., 2000*